

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Амгалан дулааны станц” ХХК-ийн 2018 оны санхүүгийн
тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/88/СТА-ТӨҮГ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл.....	8
2.8.2	Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал.....	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
3	Менежментийн захидал.....	11
3.1	Худалдан авалттай холбоотой асуудал.....	11
3.2	Хувь хүний орлогын албан татвартай холбоотой асуудал.....	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	13
4.2	Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	15
4.3	Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.4	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	18
4.5	Аудит хийсэн Зорилтот түвшний тайлан	20
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.20 № 06/522
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Амгалан дулааны станц” ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Амгалан дулааны станц” ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Амгалан дулааны станц” ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Амгалан дулааны станц” ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

“Амгалан дулааны станц” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг “Амгалан дулааны станц” ХХК-ийн захирал Ш.Баянмөнх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Амгалан дулааны станц” ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

“Амгалан дулааны станц” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Амгалан дулааны станц” ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрөөс 2019 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Од бүртгэл аудит” ХХК-ийн ахлах аудитор Н.Дагийрагчаа, аудиторовн туслах Т.Отгончимэг, Ж.Сүрэнхорлоо нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Амгалан дулааны станц” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланг “Од бүртгэл аудит” ХХК-д 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 01/104 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн боловч Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацааг 10 хоногоор хоцроосон.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Амгалан дулааны станц” ХХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Амгалан дулааны станц” ХХК нь орчин үеийн дэвшилтэт технологиор эрчим хүчний системийн найдвартай ажиллагааг хангахад оршино гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Монгол Улсын Засгийн Газрын 2013 оны 35, 55 дугаар тогтоолоор Улаанбаатар хотын гэр хорооллыг орон сууцжуулах, хотын зүүн бүсийн байгууллага, иргэдийг чанартай дулааны эрчим хүчээр хангах зорилгоор 348 мвт-ын хүчин чадалтай “Амгалан дулааны станц”-ыг барьж байгуулахаар шийдвэрлэсэн. Энэхүү шийдвэрийн дагуу Монгол Улсын Засгийн Газрыг төлөөлж Эрчим Хүчний Яам, Эдийн Засгийн Хөгжлийн Яам хамтран БНХАУ-ын “Чайна Машинери Инженеринг Корпораци”-тай Баянзүрх дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Амгалан дулааны станц”-ыг түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр барьж байгуулах концессын гэрээг 2013 оны 4 дүгээр сард байгуулснаар барилга угсралтын ажил 2013 оны 8 дугаар сарын 21-ний өдөр эхэлсэн. “Амгалан дулааны станц” ХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Дулааны эрчим хүчний үйлдвэрлэл эрхэлж, хэрэглэгчдийг дулааны эрчим хүчээр хангах ажил үйлчилгээ

“Амгалан дулааны станц” ХХК-ийн үндсэн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Амгалан дулааны станц” ХХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Монгол Улсын үндсэн хууль
- Компанийн тухай хууль
- Эрчим хүчний тухай хууль

- Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон албаны нууцын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Авлигын эсрэг хууль
- Галын аюулгүй байдлын тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
- Архивын тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Иргэний тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Тамхины хяналтын тухай хууль
- Инновацийн тухай хууль
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын тухай хуулийн шимтгэлийн хувь хэмжээнд болон Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хөнгөлөлтийн хэмжээ шатлалтай болж өөрчлөлтүүд орсон бөгөөд оны эхнээс мөрдөгдсөн байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

“Амгалан дулааны станц” ХХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

“Амгалан дулааны станц” ХХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Амгалан дулааны станц” ХХК-ийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн ERP програм хангамж ашигладаг байна.

“Амгалан дулааны станц” ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Амгалан дулааны станц” ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, зорилтот түвшний тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 15 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 15 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр “Амгалан дулааны станц” ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангын орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 2 хувиар сонгов.

Энэ нь төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн хувьд санхүүгийн тайлан хэрэглэгчид болон хувьцаа эзэмшигчдэд нийт орлогын дүн чухал нөлөөтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

“Амгалан дулааны станц” ХХК-ийн 2018 оны нийт орлого 17,421.8 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 348.4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь сонгосон суурь үзүүлэлтийн эрсдлийг дунд гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 17 горим сорил төлөвлөн гүйцэтгэж, үнэлэхэд 17 асуудлаас 10 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж

шийдвэрлэснээс гадна 3,482.3 сая төгрөгийн 5 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж 76.1 сая төгрөгийн 2 асуудалд зөвлөмж өглөө.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, “Амгалан дулааны станц” ХХК-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

- БНХАУ-ын “Чайна Машинери Инженеринг Корпораци” компаниас 2015 онд үнэ төлбөргүйгээр хүлээн авсан 47-43 УБӨ болон 56-53 УБӨ улсын дугаартай автомашинуудыг тайлант онд үнэлж бүртгэлд тусгахдаа хойшлогдсон орлогоор хүлээн зөвшөөрөх 155.0 сая төгрөгийг нэмж төлөгдсөн капитал дансанд бүртгэсэн
- Харуулын байр №1 хөрөнгийн үнэ цэнэ 26.6 сая төгрөгөөр буурсан ба уг бууралтыг дахин үнэлгээний нөөц дансны бууралт байдлаар бүртгэсэн
- Тээврийн хэрэгслүүдийн урсгал засварын зардлын хязгаарыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу шалгахад 47-43 УБӨ улсын дугаартай Хово тээврийн хэрэгсэлтэй хамааралтай 6.3 сая төгрөгийн их засварын зардлыг татвар ногдох орлогоос хасч тооцсон
- Хойшлогдсон татварын хөрөнгийг 78.7 сая төгрөгөөр дутуу, хойшлогдсон татварын өр төлбөрийг 192.1 сая төгрөгөөр илүү тооцоолсонтой хамааралтайгаар орлогын албан татварын зардал 270.9 сая мянган төгрөгөөр илүү бүртгэсэн
- Үндсэн хөрөнгийн элэгдлийг 2,752.7 сая төгрөгөөр дутуу байгуулсан зэргийг тус тус залруулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	76.1	
2	Албан шаардлага өгсөн	1	0	
	Дүн	3	76.1	

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

“Амгалан дулааны станц” ХХК тайлант онд 9 барилгыг 2,496.1 сая төгрөг, газар эзэмших эрхийг 13,005.8 сая төгрөгөөр хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэсэн. 2019 оны санхүүгийн

тайлангийн аудитаар дахин үнэлгээ хийсэн хөрөнгө болон үндсэн хөрөнгийн элэгдлийг холбогдох стандарт, хууль журмын дагуу хийгдсэн эсэхийг давтан тооцоолох.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн гүйцэтгэх захирал нь батлагдсан зорилтот түвшин, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

“Амгалан дулааны станц” ХХК нь 2018 онд 17,702.3 сая төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого, 75.0 сая төгрөгийн бусад орлого олохоор зорилтот түвшингээ баталсан байна. Батлагдсан зорилтот түвшин, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Зорилтот түвшингийн нийт зардал 24,016.1 сая төгрөг буюу 113.1 хувьтай байгаа нь үйл ажиллагааны зардал 257.3 сая төгрөгөөр дутуу, элэгдлийн зардал 3,018.6 сая төгрөгөөр илүү зарцуулагдсан нь нөлөөлсөн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

“Амгалан дулааны станц” ХХК Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

“Амгалан дулааны станц” ХХК Шилэн дансны хуулийн дагуу тус байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн shilendans.gov.mn хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлангийн талаар 132, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн мэдээллийн талаар 16, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдэлийн талаар 40, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн талаар 153, нийт 341 мэдээллийг боловсруулан хуулийн хугацаанд байршуулсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 8 зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 97 хувьтай байна.

Нүүрсийг орлого авах тухай бүрд хэмжилт хийж байх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй ба зөвлөмжийг өгөх үед 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлагдсан байсан тул хэмжилт хийх пүүг худалдан авах эх үүсвэрийг батлуулж чадаагүй, 2019 оны худалдан авалтын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд аудитын гүйцэтгэлийн үе шатанд дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Амгалан дулааны станц” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Амгалан дулааны станц” ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Амгалан дулааны станц” ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмж цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор доор эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Худалдан авалттай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Худалдан авалтын төлөвлөгөөний дагуу холхивч худалдан авахад 13.4 сая төгрөг, суудлын авто машины сэлбэг худалдан авахад 12.3 сая төгрөг, хар өнгөт металл худалдан авахад 12.1 сая төгрөг, сэлбэг, бараа материал худалдан авахад 12.8 сая төгрөг, жийрэг, жийргэвчний материал худалдан авахад 12.4 сая төгрөг, нийт 63.0 сая төгрөгийн худалдан авалтыг тодорхой үндэслэлгүй задалж шууд худалдан авалтын аргаар худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д “*харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар*”, 33 дугаар зүйлийн 33.1-д “*Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно*” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлангийн бараа материалын үлдэгдэл илүү, дутуу илэрхийлэгдэх, хөрөнгө оруулалтын зардал зориулалт бусаар зарцуулагдах.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 болон 33 дугаар зүйлийн 33.1-ийг мөрдөж ажиллах, дээрх алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

3.2 Хувь хүний орлогын албан татвартай холбоотой асуудал

3.1.2 Илрүүлэлт:

1. Нийгмийн даатгалын тайланд тайлагнасан цалинг Хувь хүний орлогын албан татварын тайланд тайлагнасан цалин түүнтэй адилтгах орлоготой тулган шалгахад Хувь хүний орлогын албан татварын тайланд цалин түүнтэй адилтгах орлогыг 2.4 сая төгрөгөөр дутуу, 10.5 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна. Дээр дурьдсан алдаанаас болж Хувь хүний орлогын албан татварын тайлангийн цалин түүнтэй адилтгах орлогын дүн 8.1 сая төгрөгөөр илүү тайлагнагдсан байна.

2. 2018 онд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн албан татварын хөнгөлөлтийн дүн шинэчлэгдсэнтэй холбоотойгоор санхүүгийн програмын тохируулгыг зөрүүтэй хийсний улмаас 0.2 сая төгрөгийн цалинг ажилчдад дутуу олгосон байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д “Энэ хуулийн 11.1.1-11.1.6-д заасан орлогод ногдох жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт үзүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Хувь хүний орлогын албан татварын тайлангийн цалин түүнтэй адилтгах орлогын дүн болон санхүүгийн тайлангийн Хувь хүний орлогын албан татварын авлага, өглөгийн дүн илүү, дутуу илэрхийлэгдэх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Хувь хүний орлогын албан татварын тайланг засаж тайлагнах, татварын хөнгөлөлтийн дүнгээр санхүүгийн програмд тохируулга хийлгэх, дээрх алдаа зөрчлүүдийг дахин гаргахгүй байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	62,855,153.20	27,046,350.72
1.1.2	Дансны авлага	9,791,193.96	2,873,531,628.85
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	-	40,845.28
1.1.4	Бусад авлага	2,174,459.92	50,000.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	1,192,514,064.22	926,647,390.61
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	34,850,142.80	96,501,610.46
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,302,185,014.10	3,923,817,825.92
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	105,771,694,931.37	102,102,761,634.72
1.2.2	Биет бус хөрөнгө	113,185,675.60	13,106,421,742.16
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	146,022,762.42	242,007,860.12
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	106,030,903,369.39	115,451,191,237.00
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	107,333,088,383.49	119,375,009,062.92
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	214,503,620.07	2,068,108,940.72
2.1.1.2	Цалингийн өглөг	733,083.64	1,569,030.67
2.1.1.3	Татварын өр	83,491,290.42	446,006,664.74
2.1.1.4	НДШ–ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		

“Амгалан дулааны станц” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	60,273,857.00	104,178,370.78
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	359,001,851.13	2,619,863,006.91
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	197,738,162.91	556,040,309.16
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	1,039,440,132.23	1,281,404,609.48
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,237,178,295.14	1,837,444,918.64
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,596,180,146.27	4,457,307,925.55
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	109,934,367,286.40	109,934,367,286.40
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		2,496,116,697.19
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		13,005,849,600.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(4,197,459,049.18)	(10,518,632,446.22)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	105,736,908,237.22	114,917,701,137.37
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	107,333,088,383.49	119,375,009,062.92

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	13,154,810,950.50	17,836,432,786.80
2	Борлуулалтын өртөг	(17,720,369,109.20)	(22,146,564,606.17)
3	Нийт ашиг(алдагдал)	(4,565,558,158.70)	(4,310,131,819.37)
4	Түрээсийн орлого	3,677,363.64	9,450,000.00
5	Хүүгийн орлого	33,399,577.37	14,100,069.19
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	72,923,758.69	96,419,341.21
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	(1,444,482,094.38)	(1,736,717,964.76)
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	(87,035,066.97)	(106,204,756.88)
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		(26,573,350.60)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(5,987,074,620.35)	(6,059,658,481.21)
19	Орлогын татварын зардал	(55,055,357.30)	(263,727,055.45)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(6,042,129,977.65)	(6,323,385,536.66)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(6,042,129,977.65)	(6,323,385,536.66)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	здийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл				1,750,469,935.42	1,750,469,935.42
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
3	Залруулсан үлдэгдэл				94,200,993.05	94,200,993.05
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)				(6,042,129,977.65)	(6,042,129,977.65)
5	Бусад дэлгэрэнгүй орлого					
6	Өмчид гарсан өөрчлөлт	109,934,367,286.40				109,934,367,286.40
7	Зарласан ногдол ашиг					
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
9	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	109,934,367,286.40			(4,197,459,049.18)	105,736,908,237.22
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
11	Залруулсан үлдэгдэл				2,212,139.62	2,212,139.62

“Амгалан дулааны станц” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(6,323,385,536.66)	(6,323,385,536.66)
13	Бусад дэлгэрэнгүй орлого		2,496,116,697.19	13,005,849,600.00		15,501,966,297.19
14	Өмчид гарсан өөрчлөлт					
15	Зарласан ногдол ашиг					
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
17	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	109,934,367,286.40	2,496,116,697.19	13,005,849,600.00	(10,518,632,446.22)	114,917,701,137.37

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	14,872,774,565.35	17,289,360,615.38
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	14,731,409,682.95	16,760,174,042.36
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	177,602.00	
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	141,187,280.40	529,186,573.02
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	14,895,828,765.06	16,727,278,490.95
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,114,775,836.98	2,820,704,031.31
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	573,234,945.38	817,170,333.55
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	6,037,770,186.59	6,454,978,526.35
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	4,097,362,759.10	4,864,944,902.53
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	316,525,124.80	72,357,100.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	996,427,047.22	921,171,286.62
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		530,550.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	759,732,864.99	775,421,760.59
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(23,054,199.71)	562,082,124.43
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	33,396,888.92	14,100,069.19
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	33,396,888.92	14,100,069.19
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	650,240,928.00	482,175,131.10
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	599,272,261.00	481,625,131.10

2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	50,968,667.00	
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		550,000
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(616,844,039.08)	(468,075,061.91)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	30,431,905.05
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	30,431,905.05
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	160,247,770.05
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	160,247,770.05
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	(129,815,865.00)
4	Валютын ханшийн зөрүү		-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(639,898,238.79)	(35,808,802.48)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	702,753,391.99	62,855,153.20
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	62,855,153.20	27,046,350.72

4.5 Аудит хийсэн Зорилтот түвшний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

№	Зардлын төрлүүд	Тодотгосон төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт +, хэмнэлт -	Хувь
1.ОРЛОГО					
1.1	Үндсэн үйл ажиллагааны орлого	17,702,344,759.80	17,836,432,786.80	134,088,027.00	100.76
1.2	Бусад орлого	74,954,393.00	119,969,410.40	45,015,017.40	160.06
Дүн		17,777,299,152.80	17,956,402,197.20	179,103,044.40	101.01
2.ЗАРЛАГА					
1	Түлшний зардал	8,458,850,300.00	8,317,157,379.66	(141,692,920.34)	98.32
2	Туслах материалын зардал	46,832,900.00	42,790,994.61	(4,041,905.39)	91.37
3	Шатахууны зардал	92,995,300.00	79,644,073.43	(13,351,226.57)	85.64
4	Элс /шаарга, шохой/-ний зардал	-	-	-	-
5	Сэлбэг хэрэгсэл, материал хангамж	104,406,300.00	103,892,765.35	(513,534.65)	99.51
6	Урсгал засвар	185,966,700.00	162,310,754.70	(23,655,945.30)	87.28
7	Үндсэн ба нэмэгдэл цалин урамшуулал	3,221,975,321.74	3,220,550,048.98	(1,425,272.76)	99.96
8	Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	470,114,200.00	469,694,212.42	(419,987.58)	99.91
9	Ашиглалтын зардал /цахилгаан/	3,446,980,600.00	3,440,859,942.42	(6,120,657.58)	99.82
10	Ашиглалтын зардал /ус/	23,842,800.00	22,952,481.95	(890,318.05)	96.27
11	Албан томилолтын зардал	2,420,000.00	1,716,544.40	(703,455.60)	70.93
12	Конторын хангамжийн зардал	52,381,130.00	41,432,799.44	(10,948,330.56)	79.10
13	Хэвлэл захиалга	2,299,700.00	2,245,492.73	(54,207.27)	97.64
14	Харилцаа холбооны зардал	12,276,500.00	9,150,217.88	(3,126,282.12)	74.53
15	Харуул хамгаалалтын зардал	72,000,000.00	71,363,636.36	(636,363.64)	99.12
16	Хөдөлмөрийн аюулгүй байдлын зардал	102,017,000.00	99,569,952.79	(2,447,047.21)	97.60
17	Даатгалын зардал	1,400,000.00	628,560.00	(771,440.00)	44.90
18	Байгаль орчныг хамгаалах зардал	21,500,000.00	18,903,744.55	(2,596,255.45)	87.92
19	Галын аюулаас хамгаалах зардал	26,600,000.00	12,334,391.00	(14,265,609.00)	46.37
20	Гүйцэтгэх удирдлагын зардал	225,615,700.00	215,198,822.12	(10,416,877.88)	95.38
21	Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал	-	-	-	-
22	Борлуулалт, маркетингийн зардал	-	-	-	-
23	Гадаад ажилчдын хөдөлмөр эрхлэх	-	-	-	-
24	Зохицуулах үйлчилгээний хөлс	73,480,000.00	73,480,000.00	-	100.00
25	Гадны үйлчилгээний хөлс	40,899,800.00	35,525,491.82	(5,374,308.18)	86.86

“Амгалан дулааны станц” ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

26	Түрээсийн зардал	-	-	-	-
27	Сургалтын зардал	55,312,600.00	41,425,119.03	(13,887,480.97)	74.89
28	Найдваргүй авлагын зардал	-	-	-	-
29	Үйл ажиллагааны бусад зардал	-	-	-	-
Үйл ажиллагааны зардлын дүн		16,740,166,851.74	16,482,827,425.64	(257,339,426.10)	98.46
30	Ерөнхий хэрэглээний үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	606,394,624.36	577,075,079.06	(29,319,545.30)	95.16
31	Үйлдвэрлэлийн зориулалттай үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	3,484,167,757.89	6,532,110,767.06	3,047,943,009.17	187.48
Элэгдлийн зардлын дүн		4,090,562,382.25	7,109,185,846.12	3,018,623,463.87	173.79
32	Үл хөдлөх хөрөнгийн татвар	159,153,743.12	164,552,272.28	5,398,529.16	103.39
33	АТӨЯХ-н албан татвар	1,684,563.00	1,634,563.00	(50,000.00)	97.03
34	Газрын төлбөр	14,118,192.00	14,118,192.00	-	100.00
35	Усны нөөц ашигласны төлбөр	6,583,500.00	3,354,478.00	(3,229,022.00)	50.95
36	Бусад татвар хураамж	-	-	-	-
Орлогын албан татвараас бусад татвар		181,539,998.12	183,659,505.28	2,119,507.16	101.17
Бүрэн өөрийн өртөг		21,012,269,232.11	23,775,672,777.05	2,763,403,544.94	373.43
37	Урт хугацаат зээлийн хүүгийн зардал	-	-	-	-
38	Ажилчдын нийгмийн зардал	213,904,700.00	213,814,550.77	(90,149.23)	99.96
39	Бусад	-	-	-	-
ХОӨ-өөр нөхөгдөх зардал		213,904,700.00	213,814,550.77	(90,149.23)	99.96
40	Үйл ажиллагааны бус бусад зардал	-	26,573,350.60	26,573,350.60	-
Үйл ажиллагааны бус бусад зардал		-	26,573,350.60	26,573,350.60	-
НИЙТ ЗАРДАЛ		21,226,173,932.11	24,016,060,678.42	2,789,886,746.31	113.14
АШИГ АЛДАГДАЛ		(3,448,874,779.31)	(6,059,658,481.22)	(2,610,783,701.91)	175.70

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:
2019.03.19

Аудитын
нэр:

Амгалан дулааны станц
ХХК-ийн 2018 оны
санхүүгийн тайлангийн
аудит

Аудитын
код:

САГ-
2019/88/
СТА-
ТӨҮГ

Шалгагдсан байгууллагын нэр:

Амгалан дулааны станц ХХК

Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Албан тушаал	Овог нэр
А	З	4	5		9	10
1	Нийгмийн даатгалын тайланд тайлагнасан цалинг ХХОАТ-ын тайланд тайлагнасан цалин түүнтэй адилтгах орлоготой тулган шалгахад ХХОАТ-ын тайланд цалин түүнтэй адилтгах орлогыг 2.4 сая төгрөгөөр дутуу, 10.5 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.	12.8	Зөвлөмж өгөх, залруулга хийх	Зөвлөмж өгөх, залруулга хийх	Ерөнхий нягтлан бодогч Тооцооны нягтлан бодогч	Ч.Бямбаа Э.Наранбаатар
2	ХХОАТ-ын тухай хуулийн албан татварын хөнгөлөлтийн дүн шинэчлэгдсэнтэй холбоотойгоор 0.2 сая төгрөгийн цалинг ажилчдад дутуу олгосон байна.	0.2	Зөвлөмж өгөх, залруулга хийх	Зөвлөмж өгөх, залруулга хийх	Ерөнхий нягтлан бодогч Тооцооны нягтлан бодогч	Ч.Бямбаа Э.Наранбаатар
3	Худалдан авах төлөвлөгөөний дагуу холхивч худалдан авахад 13.4 сая төгрөг, суудлын авто машины сэлбэг худалдан авахад 12.3 сая төгрөг, хар өнгөт металл худалдан авахад 12.1 сая төгрөг, сэлбэг, бараа материал худалдан авахад 12.8 сая төгрөг, жийрэг, жийргэвчний материал худалдан авахад 12.4 сая төгрөг, нийт 63.0 сая төгрөгийн худалдан авалтыг тодорхой үндэслэлгүй задалж шууд худалдан авалтын аргаар худалдан авсан байна.	63.0	Зөвлөмж өгөх	Зөвлөмж өгөх	Дэд захирал ААХА-ны дарга	Б.Төрмөнх Г.Амарбаясгалан
		76.1				

